



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 11201

Мандалговь

Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах  
тусгай зөвшөөрөл сунгах тухай


Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.12.3, дэх заалт, Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох салбар комиссын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хавсралтанд дурдсан эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасугай.

Хоёр. Эрүүл мэндийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Уламжлалт анагаах ухааны төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS5700:2006, Сувиллын бүтэц, үйл ажиллагаа MNS 5232:2013, Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS5203:2002, Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015 болон өөрсдийн үйл ажиллагаанд холбогдох бусад стандартын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эмнэлэг, эмийн сангийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг тусгай зөвшөөрөл олгох салбар комисс /Ц.Эрдэнэсүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/, Эрүүл мэндийн газар /Ц.Энхсайхан/ нарт тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



О.БАТ ЭРДЭНЭ

0200582

Аймгийн Засаг даргын 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 421 тоот захирамжийн хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Үүсгэн байгуулагчийн нэр	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар	“Уламжлалт анагаах ухааны төв”	Уламжлалт анагаах ухааны оношлогоо эмчилгээ	ЭУ-15/10/1001	3 жил
2	“Онги есөн эрдэнэ” ХХК	“Төгс дэлгэц” эмнэлэг	Хэт авиа оношлогоо	ЭСХ-14/02/973	3 жил
3	“Өөштүр” ХХК	“Өөш манхан” сувилал	Сувилахуйн тусламж, үйлчилгээ	ЭХ-15/10/1024	3 жил
4	ОНӨААТҮГ	Говь-Угтаал ЭЭСан	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	ЭСХ-15/10/1007	3 жил
5	ОНӨААТҮГ	Цагаандэлгэр ЭЭСан	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	ЭСХ-15/10/1009	3 жил

ЗАСАГ ДАРГА

О БАТ ОРДОНЗ

0220582